


Сургуулийн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-нд тусгасны дагуу болзошгүй газар хөдлөлтийн үед авах эхний гурав болон иргэн бүрийн нэн яаралтай авч хэрэгжүүлэх 10 алхмыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Болзошгүй газар хөдлөлтийн үед авч хэрэгжүүлэх эхний 3 алхам.

1. Барилга байгууламжид байгаа нийт хүмүүсийн аюулгүй байдлыг хангуулах “НУУГД-СУУ-ХҮЛЭЭ” зарчмын дагуу ажиллах, аюулгүй газарт яаралтай гаргах,
2. Газар хөдлөлтийн дохио өгч байгаа үед гарц, хаалгуудыг яаралтай нээн, хүмүүсийг чөлөөтэй гарах боломжоор хангах,
3. Зарлан мэдээллийг дамжуулах, мэрэгжлийн анги, штабыг үүрэгжүүлэх, үйл ажиллагаанд оруулах.

ГАМШГИЙН ҮЕД ШУТИС-ИЙН ЗАРЛАН МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ СХЕМ



Газар хөдлөлтийн үед нэн яаралтай авах 10 АЛХАМ

Газар доор болон гадарга дээр их хэмжээний чичирхийлэлт болж, хүчтэй үйлчлэлийн улмаас газрын гадаргад ан цав бий болохыг газар хөдлөлт гэнэ.

Ойртон ирж байгаа газар хөдлөлтийн шинж тэмдгүүд:

Байшин донслон хөдлөх, чийдэнгийн бүрхүүл болон өлгөөтэй эд зүйлс саваах, шилэн сав суулга харших, дуугарах, хагарч буй шилний чимээ гарах, хүнгэнэсэн дуу ойртох. Ийм шинж тэмдэг мэдрэгдвэл байшин барилгыг яаралтай орхих, хүмүүсийг гадагш яаралтай гаргах, эсвэл тасалгааны аюулгүй байрыг эзлэх хэрэгтэй.


1. ӨӨРИЙГӨӨ БОЛОН ГЭР БҮЛЭЭ ХАМГААЛАХ

Хүчтэй чичиргээ ихэнхдээ 1 минут орчим үргэлжлэх тул бат бөх ширээн доор орж толгойгоо хамгаалах. Овор ихтэй тавилга болон цонхноос хамгаалах ханан талд очиж суух.



2. ЦАХИЛГААН ХЭРЭГСЛЭЭ САЛГАХ

Цахилгаан хэрэгсэл, тухайлбал цахилгаан болон хийн зуухыг салгах. Гал гарсан тохиолдолд нэн даруй унтраах.



3. ТАЙВАН БАЙХ

Орчин тойрноо ажиглаж, тайван байх хэрэгтэй. Цахилгаан шат ашиглахыг хориглоно.



4. ХААЛГАА ОНГОЙЛГОХ

Хаалган дор зогсоход аюул багатайгаас гадна гадагш гарахад тустай.



5. ГАДАА БАЙХ ҮЕД

Гудамжинд явж байхад газар хөдлөлт болбол барилгын тоосго, мод, цонхны шил, гэрэлтүүлгийн болон зар сурталчилгааны багана, самбар зэрэг гэмтээж болох зүйлээс хол байж, задгай талбай олж зогсох.



6. ОЛОН НИЙТИЙН ГАЗАРТ

Дэлгүүр, зах, үзвэр, үйлчилгээний газар гэх мэт олон хүнтэй орчинд хүмүүс сандралд орж үймээн, шуугиан үүсдэг. Иймд тайван байж, сандарч тэвдэхгүйгээр тухайн байгууллагын ажилтны заавар зөвлөгөөг дагах.



7. АВТОМАШИНААР ЯВАХ ҮЕД

Автомашинаар зорчиж яваа тохиолдолд нэн даруй зогсож радиогоор өгөх мэдээллийг сонсох хэрэгтэй. Нүхэн гарцын дор, өндөр барилгын хажууд зогсож болохгүй.



8. ГОЛ, УСНААС ХОЛ БАЙХ

Гол, устай газрын ойролцоо байдаг бол нэн яаралтай өндөрлөг газар очих.



9. ШИЛЖИН БАЙРЛАХ ҮЕД

Аль болох бага эд зүйл авч, явганаар шилжин байрлах. Автомашинаар зорчих нь замын түгжрэлд орохоос гадна аврах ажиллагаанд саад болж болзошгүй.



10. МЭДЭЭЛЭЛ ЗӨВ АВАХ

Гамшгийн үед хүмүүс цуу ярианд автах, төөрөлдөх явдал их байдаг тул нутгийн захиргааны болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагаас өгч буй бодит мэдээлэлд анхаарлаа хандуулах.



ХҮН НЭГ БҮРИЙН ҮҮРГЭВЧИНД БАЙХ БАЙВАЛ ЗОХИХ ЗҮЙЛС



ЦЭВЭР УС

1.5 литрээс багагүй байх бөгөөд жижиг савалгаатай байвал зохимжтой.



ХҮНС

Лаазалсан болон хатаасан удаан хугацаагаар хадгалах боломжтой, /өдөрт 3 удаа, 3 хоног хооллохоор тооцож/

АНХНЫ ТУСЛАМЖИЙН ИЖ БҮРДЭЛ



ЭМЧИЙН ЖОРГУЙ ХЭРЭГЛЭХИЙГ ЗӨВШӨӨРДӨГ, ӨВЧИН НАМДААХ БОЛОН ХОДООД ГЭДЭСНИЙ ЭМ Г.М



ДУЛААН ХУВЦАС ГУТАЛ



ГАР ЧИЙДЭН, НӨӨЦ ЗАЙ



РАДИО ХҮЛЭЭН АВАГЧ, НӨӨЦ ЗАЙ



ШҮГЭЛ



Дохио өгөхөд ашиглана.

СОНИН -10 ШИРХЭГ



Биеийн дулааныг хадгалах, яс хугарсан, гэмтсэн үед чиг барих, ороох бооход ашиглана.



ЛАА, ШҮДЭНЗ

Гэрэлтүүлэх, дохио өгөх, хоол боловсруулах, дулаан гаргах, зүү, тариур, чимхүүрийг ариутгахад ашиглана.

АЯНЫ ХӨНЖИЛ



ЧУХАЛ БИЧИГ БАРИМТУУДЫН ХУУЛБАР



ӨРХИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ГАЗРЫН ЗУРАГ



АРИУН ЦЭВРИЙН БАГЦ



СКОЧ, ОЛОН ҮЙЛДЭЛТ БАГАЖ



ЦААС, ҮЗЭГ, ГАР УТАС



ҮҮРГЭВЧ



ГЯЛГАР УУТ -10 ШИРХЭГ



Хүнс, хоол хадгалах болон бэлтгэх сав, бээлий, цув, дэвсгэр болгон ашиглана.



ХҮАлба